



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 5/НБ

Хэрлэн сум

Г.Уянгыг үргэлжлүүлэн  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолын хавсралт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Гансүхийн Уянга нь хүүхэд асрах чөлөөний хугацаанаас өмнө үүрэгт ажилдаа орох хүсэлт гаргасан тул 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2.Г.Уянгын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Ундрахжаргал	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн
	С.Чулуунцэцэг	Няравын үүргийг түр орлон гүйцэтгэгч

231030140

2.

3. Г.Уянгын үндсэн цалинг ТЗ-7 зэрэглэлээр тогтоон, 1,452,000 (нэг сая дөрвөн зуун тавин хоёр мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 12 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 20 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож, олгохыг Нягтлан бодогч (Г.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Г.Уянгын ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Ц.Ганчимэг)-т даалгасугай.

5. Нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Уянгад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА